



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНГОВЬ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 62/13

Өргөн

Гэрийн тэжээвэр амьтанг тэжээх,
харж, хамгаалах журам батлах тухай

Монгол Улсын засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6.1, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.15 дахь заалтуудыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Гэрийн тэжээвэр амьтанг тэжээх, харж хамгаалах журмыг төлөөлөгчдийн саналыг тусгаснаар хавсралтаар баталсугай.

2. Журмын талаарх мэдээллийг иргэд олон нийтэд хүргэж, хэрэгжилтийг хангаж, үр дүн гарган ажиллах талаар холбогдох албан тушаалтнуудад үүрэг чиглэл өгч ажиллахыг сумын Засаг дарга /Б.Эрдэнэбилэг/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд тогтмол хяналт тавьж, биелэлт үр дүнгийн талаарх мэдээллийг жил бүр Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Чимэдцэрэн/-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсан тул Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2014 оны 12 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүйд тооцсугай.



ДАРГА *[Signature]* ЦЭЦЭГ БЭТЖАРГАЛ

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2019 оны 12 дугаар сарын 13-ны
өдрийн 12/13 дугаар тогтоолын хавсралт



ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТАНГ ТЭЖЭЭХ ХАРЖ ХАМГААЛАХ ЖУРАМ

Зорилго: Гэрийн тэжээвэр амьтанд /нохой, муур, илжиг, гахай, тахиа, туулай/-г тэжээх, харж хамгаалах, ашиглахад мөрдөх эрх зүйн баримт бичиг болох ба хариуцлага тооцоход энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Үндэслэл: Хэдийгээр хүн оршиж буй орчин, нөхцөл, өөрийн хувийн ахуйн хэрэгцээгээ хангах, орлогын эх үүсвэр бий болгох нь нээлттэй боловч орон нутгийн түвшинд ашгийн бус зөвхөн өөрийн эзэмшил, хувийн өмчөө хамгаалах зорилготойгоор дээрх амьтдаас нохойг тэжээж байна. Энэ нь тухайн айл өрхөд /суурингийн/ орлого бий болгож ашиг өгч буй бус амьдралын нийтлэг хэв маягийг харуулах төдий байна.

Сууринд нохойноос үүдэлтэй олон сөрөг үр дагавар бий болж улмаар иргэдийн эрүүл мэнд, эдийн засагт ихээхэн хэмжээний хохирол учруулж буй нь тодорхой юм.

Мөн орчны ариун цэврийг дээд зэргээр бохирдуулахын сацуу сүүлийн үед гэрийн тэжээвэр амьтнаас үүдэлтэй эргүү, шар өвчинүүд ихээр гарч байна. Нохойг тэжээгч эздүүд нь үл хайхран нэр төдийгээр тэжээж буй нь зэлүүд нохойн сүрэг бий болох, хөдөөд буй малчин өрхүүд хоточ нохойгоо гэж тэжээх боловч охин нохойн үр төлийг сууринд авч ирж төөрүүлдэг арга бий болсноор суурингийн нохой өсч олшрон дээрх сөрөг үр дагавруудыг бий болгож байна.

Нохой, муурыг гэрийн тэжээвэр амьтан болгон ашиглах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд мөрдөх журмын заалтууд.

1.Хоточ цэвэр монгол банхарын удам угшилтай нохойг тэжээж ашиглаж, эзэмших

2.Нохой, муурийг өөрийн эзэмшлийн хашаанд байнгын хараа хяналттай болгож тэжээх

3.Эзэмшлийн нохой, муур нь оноосон, ариун цэвэр халдваргүйжүүлэлтэд мал эмнэлэгийн дүгнэлттэй байх

4.Жил бүр бүртгэлд хамарч тарилга туулгалтад хамрагдсан мал эмнэлгийн дүгнэлттэй байх

5.Нохойг үржилд /нийлүүлэгт/ оруулахгүй байх арга хэмжээг авсан байх /эм тариа хэрэглэх, агтлах/

6.Нохойг өглөөний 06 цагаас оройн 23 цагийн хооронд байнгын уяанд оруулж өөрийн эзэмшлийн хашаанд байлгаж хэвшүүлэх

7.Бусад тэжээвэр амьтдыг өрхийн орлого бий болгох цаашид орон нутгийн болоод гадаад зах зээлд борлуулалт нийлүүлэлт хийх, жижиг дунд үйлдвэрлэлийн түвшинд хүргэх зорилт тавих, түүнд бодлогоор төрөөс дэмжлэг үзүүлэх.

8.Нохой, муурийг татварыг орон нутгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор батлан тогтоож орон нутгийн орлогод төвлөрүүлж журамд заасан үйл ажиллагааны зардалд зарцуулах.

9.Татвар ноогдуулахдаа БИНХ-р хэлэлцүүлж саналыг үндэслэн тогтоох,
/БИНХ-р гарсан санал эр нохой 8000 төгрөг, охин нохой 20.000 төгрөг, муур 20.000 төгрөг/.

10.Гэрийн тэжээвэр амьтан тэжээсэн иргэн хуулийн хугацаанд албан татвараа бүрэн төвлөрүүлэх

11.Жил бүрийн жилийн эцсийн тооллогын үеэр сумын хэмжээний нохойны тоог багийн Засаг дарга нар өрхийн нэрээр дэлгэрэнгүй судалгааг гаргаж, нохой, муурны албан татварыг тооцож орлогод, төвлөрүүлэх

12.Энэ журмыг ард иргэдэд сурталчилах , мэдээлэлээр хангах ажлыг ХАА-н тасаг хариуцан зохион байгуулах

13.Нохой, муурнаас бусад гэрийн тэжээвэр амьтдыг өрхийн аж ахуйн орлого бий болгохоор үржүүлэх тохиолдолд төрийн болон гадны төсөл хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгийн хөрөнгө санхүүгээр дэмжиж, зээлд хамруулах

14.Нохойны түүхий эд материалыг зах зээлд борлуулж орлогын эх үүсвэрийг бий болгох ажлыг судлах, ашиглах хөдөлгөөн өрнүүлж сурталчилан тагиулах зах зээлд борлуулалт хийх бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх.

15.Татварын орлогын тооцож төвлөрүүлэх, зарцуулалтад хяналт тавих эрхийг төсвийн ерөнхийлөн захирагч , төрийн санч, татварын байцаагч, багийн Засаг дарга нар хамтран хэрэгжүүлэх эрх үүргийг эдлэх

16.Нохой болон бусад тэжээвэр амьтадыг эрүүлжүүлэх болон бусад арга хэмжээг хувийн мал эмнэлэгээс авч хэрэгжүүлэх ба гарах зардлыг тооцон эзэн /тэжээгч/ өөрөө хариуцах

17.Нохойг цөөрүүлэх зорилгоор өөрийн санаачлагаар нохойг устгал хийж буй иргэнд устгасан нохойн тоо, нотлох баримтыг үндэслэн урамшуулал олгох

18. Нохой болон гэрийн тэжээвэр амьтадаас авах татварын хэмжээг эр нохой 8000, охин нохой 20000, муур 20000 төгрөг.

Хариуцлага тооцох, түүнийг хэрэгжүүлэх албан тушаалтнууд

-Тухайн хувь хүн, өрхийн гишүүн нохойд хазуулах, малаа бариулах зэрэгт эзэн холбогдогчийг тогтоож зохих хууль эрх зүйн актуудын дагуу хохирол учруулсан зардлыг тухайн эзэн бүрэн хариуцна.

-Хувийн мал эмнэлгийн эзэн, мэргэжилтнүүд тарилга, туулга халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг авч ажиллах

-Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч олон нийтийн цагдаагийн ажилтан, Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, цагдаа, багийн Засаг дарга нар нь зохих хууль журмын хэрэгжилтийг хангахад хууль эрх зүйн хүрээнд хамтран ажиллах.

Энэ журмын хэрэгжилтийг жил бүр үр дүнг тооцож тайлагнаж ажиллах ба журмыг эрх зүйн хэм хэмжээний актын бүртгэлд бүртгэгдснээс эхлэн дагаж мөрдөнө.

_____оОо_____